МОНГОЛБАНК
**САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3,
Утас: 32 68 03, Факс: (976-11) 31 14 71
И-мэйл: fiuforpublic@mongolbank.mn

2024.06.21 № 49

танай ____________-ны №____________-т

МОНГОЛЫН НОТАРИАТЧДЫН
ТАНХИМД

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 2024 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/184 тоот тушаалыг хүргүүлж байна.

Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 2 хуудастай.

ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БӨГӨӨД САНХҮҮГИЙН
МЭДЭЭЛЛИЙН
АЛБАНЫ ДАРГА Б.БАТБААТАР

УХА0496

15430077

A5-2024.doc

МОНГОЛЫН
НОТАРИАТЧДЫН ТАНХИМ
ХНТ5407

Бүртгэсэн № 286 Карт № ...
20 24 оны 06 сарын 26 өдөр
11 цаг 25 минутанд
[illegible] д
шилжүүлэв.

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,**
**ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2024 оны 06 сарын 14 өдөр Дугаар А/189 Улаанбаатар хот

Төлөвлөгөөнд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолын 3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 144 дүгээр захирамжаар батлагдсан Үндэсний зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний Зорилт 1.6-ын 21 дүгээр ажлын дараа дор дурдсан агуулгатай $21^1$ дэх хүснэгт нэмсүгэй:

1/ $21^1$;

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | $21^1$ | Шууд хэрэгжилтийн 11 үзүүлэлтийн дагуу МУТС болон ҮОХЗДС тогтолцооны үр дүнтэй байдлын үнэлгээ хийхэд шат дараатайгаар бэлтгэх, үнэлгээг хийх | Жил бүр | ХАЗ-ийн шийдвэрээр байгуулагдах Ажлын хэсэг | |

2.Мөн төлөвлөгөөний Зорилт 1.1-ийн 2 дугаар ажлын “Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ” баганад "...үүргийг хуульчлах" гэсний дараа "талаар судалж, хууль санаачлагчид уламжлах" гэж, Зорилт 1.5-ын 17 дугаар ажлын “Үндсэн хэрэгжүүлэх байгууллага” баганад “СЗХ” гэсний дараа “,МБ, СМА” гэж, Зорилт 5.5-ын 104 дүгээр ажлын “Хамтран хэрэгжүүлэх байгууллага” баганад “...СМА” гэсний дараа “, ЦЕГ, ТЕГ” гэж, Зорилт 7.2-ын 157 дугаар ажлын “Хамтран хэрэгжүүлэх байгууллага” баганад “...ажлын хэсэг” гэсний дараа “, СЗХ” гэж, Зорилт 7.3-ын 173 дугаар ажлын “Үндсэн хэрэгжүүлэх байгууллага” баганад “...ЦЕГ” гэсний дараа “, УДШ” гэж, Зорилт 8.3-ын 194 дүгээр ажлын “Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ” баганад “...хууль журамд тусгах” гэсний дараа “ төслийг боловсруулж, хууль санаачлагчид уламжлах” гэж тус тус нэмсүгэй.

15100743

3.Мөн төлөвлөгөөний Зорилт 1.1-ийн 2 дугаар ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2024 он” гэснийг “2024-2025 он” гэж, Зорилт 1.2-ын 8 дугаар ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023 он” гэснийг “2023-2024 он” гэж, Зорилт 1.5-ын 18 дугаар ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2025 он” гэснийг “2024-2026 он” гэж, Зорилт 2.3-ын 29 дүгээр ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “Жил бүр” гэснийг “Тухай бүр” гэж, Зорилт 3.7-ын 59 дүгээр ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2024 он” гэснийг “2024-2025 он” гэж, Зорилт 4.1-ийн 60 дугаар ажлын “Хамтран хэрэгжүүлэх байгууллага” баганад “МБ, СМА, ТЕГ, СЯ, ХЗДХЯ, СЗХ, УДШ, НЭХДЗШШ, ШЕЗ, УЕПГ, ГХЯ, ТТЗ, АТГ, ЦЕГ, УБЕГ, ТатЕГ, ГЕГ” гэснийг “ХАЗ-ийн гишүүн байгууллагууд” гэж, Зорилт 5.1-ийн 69 дүгээр ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2024 он” гэснийг “2025-2027 он” гэж, Зорилт 5.1-ын 72 дугаар ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023 он” гэснийг “2024 он” гэж, Зорилт 5.1-ийн 74 дүгээр ажлын “Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ” баганад “ФАТФ зөвлөмж” гэснийг “ФАТФ-ын үнэлгээний аргачлал” гэж, “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2024 он” гэснийг “2023-2028 он” гэж, Зорилт 5.2-ын 77 дугаар ажлын “Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ” баганад “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэгчийн” гэснийг “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн” гэж, Зорилт 5.2-ын 79 дүгээр ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2023 он” гэснийг “2023-2025 он” гэж, Зорилт 5.3-ын 87 дугаар ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2024 он” гэснийг “2023-2025 он” гэж, Зорилт 5.5-ын 104 дүгээр ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2024 он” гэснийг “2023-2025 он” гэж, Зорилт 5.5-ын 105 дугаар ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2026 он” гэснийг “Тухай бүр” гэж, Зорилт 5.6-ын 106 дугаар ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2026 он” гэснийг “Тухай бүр” гэж, Зорилт 5.10-ын 122 дугаар ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2023 он” гэснийг “2024-2025 он” гэж, Зорилт 5.11-ийн 131 дүгээр ажлын “Хэрэгжүүлэх хугацаа” баганад “2023-2024 он” гэснийг “2026-2028 он” гэж, Зорилт 7.2-ын 164 дүгээр ажлын “Хамтран хэрэгжүүлэх байгууллага” баганад “ХАЗ-ийн дэргэдэх Хууль сахиулах ажлын хэсэг” гэснийг “ШЕЗ, ЦЕГ, ТЕГ, АТГ, ШШГЕГ” гэж тус тус өөрчилсүгэй.

4.Мөн төлөвлөгөөний Зорилт 1.5-ын 17 дугаар ажлын “Хамтран хэрэгжүүлэх байгууллага” баганад “МБ, СМА” гэснийг, Зорилт 7.2-ын 157 дугаар ажлын “Үндсэн хэрэгжүүлэх байгууллага” баганад “СЗХ” гэснийг, Зорилт 7.2-ын 164 дүгээр ажлын “Үндсэн хэрэгжүүлэх байгууллага” баганад “ШЕЗ, ЦЕГ, ТЕГ, АТГ” гэснийг тус тус хассугай.

5.Энэ тушаалыг холбогдох байгууллагуудад хүргүүлэх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулахыг Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны дарга бөгөөд Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Батбаатар)-т даалгасугай.

Б.ЭНХБАЯР